

**ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-23
<hr/>	
<i>1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/</i>	4-14
<i>2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгээс олонхын санал авсан нэр дэвшигчийг Байнгын хороонд санал болгож томилуулах тухай/</i>	14-23

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 10 дугаар
сарын 24-ний өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны
товч тэмдэглэл**

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 35 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: С.Бямбацогт;

Чөлөөтэй: Л.Энх-Амгалан, Б.Энхбаяр.

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, мөн зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан, Ажлын албаны дарга В.Жавзан, Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Авлигатай тэмцэх газрын дэд дарга Г.Азжаргал, мөн газрын Тамгын газрын дарга З.Баасанням, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга Т.Энхболд, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, Ч.Сарантуяа нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн тавьсан асуултад Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Б.Баярсайхан нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгээс олонхын санал авсан нэр дэвшигчийг Байнгын хороонд санал болгож томилуулах тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга Т.Энхболд, Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс, Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигч Ш.Батсүх, Ч.Эрдэнэчимэг, М.Цэрэнбат нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан нар байлцав.

Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Н.Энхболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Баттөмөр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, Б.Бат-Эрдэнэ, Н.Энхболд, Б.Баттөмөр нар үг хэлэв.

Б.Баттөмөр: 1.Шаарийгийн Батсүхийг Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 1
Бүгд: 7
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Чогдогийн Эрдэнэчимэгийг Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 2
Бүгд: 7
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Минжүүрийн Цэрэнбатыг Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 1
Бүгд: 7
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Баттөмөр: “Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай”
Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 2
Бүгд: 7
71.4 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 25 минут үргэлжилж, 10 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 70.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАТТӨМӨР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим, 11 цаг 35 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Баттөмөр: Байнгын хорооны эрхэм гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгаж мэндчилье. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдаанд ирсэн гишүүдээ танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Бейсен байна. Улсын Их Хурлын гишүүн Баярсайхан, Улсын Их Хурлын гишүүн Энхболд, Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр, Улсын Их Хурлын гишүүн Баделхан, Адьшаа гишүүн хуралдаа сууна шүү. Адьшаа гишүүн ирээрэй. Бямбацогт гишүүн хуралдаа ирээрэй. Энх-Амгалан сайд хуралдаа ирээрэй. Сайд нар ингээд давхар дээл өмсчөөд Байнгын хорооныхоо хуралд суудаггүй. Нэг л их халууцсан хүмүүс давхиад байдаг. Хуралдаа суугаарай. Жавхлан сайд ирчихсэн байна. Энхбаяр сайд Байнгын хорооны дарга байхдаа ч суугаагүй, сайд болохдоо суугаагүй. Эсвэл энэ Улсын Их Хурлын удирдлагад хэлж Байнгын хорооноос гарах хэрэгтэй. Энхбаяр сайд хуралдаа ирье. Энх-Амгалан сайд хуралдаа ирье. Бямбацогт сайд хуралдаа ирье. Бямбацогт сайд томилоттой юм байна. Хурлынхаа үйл ажиллагааг үргэлжлүүлье.

Байнгын хорооны хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн

тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд. Засгийн газар 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр өргөн барьсан, 2 дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

2 дахь асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнээр сонгон шалгаруулах ажлын хэсгээс олонхын санал авсан нэр дэвшигчийг Байнгын хороонд санал болгож, томилуулах тухай асуудал байгаа.

3 дахь нь Байнгын хорооны тогтоолын төсөл гэсэн ийм 3 асуудал хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай саналтай гишүүн байна уу. Алга байна.

Монгол Улсын 2024 онд төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуулийн төслүүд 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Засгийн газраас өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг. Төсвийн байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлнэ.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдад микрофон өгье.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж, экспортыг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж, иргэдийн бодит орлогыг

хамгаалахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд улсын эдийн засаг сайжирч, улмаар урт хугацааны хөгжлийн эхний 10 жилийн зорилт болох шинэ сэргэлтийн бодлого хэрэгжүүлэх боломж бүрдээд байна. Тиймээс шинэ сэргэлтийн бодлогын гол зорилтын нэг болох хот хөдөөгийн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн төсөв, санхүүгийн багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр ирэх 2024 оны төсвийн төсөлд тусгасан болно. Тухайлбал төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлж, тэдэнд орон нутгийн нэмэгдэл олгох, орон нутагт ажилласан төрийн албан хаагч шатлан дэмжих тохиолдолд хуульд заасан тусгай шаардлагын хугацааг бууруулах зэрэг хөдөөгийн сэргэлтийн бодлогоор дэмжихэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд төлөвлөөд байна.

Шинэ сэргэлтийн бодлогыг дэмжих дээрх багц арга хэмжээг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт 7 хувьд хүрч Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25,3 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага 27,4 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал 2,1 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2,8 хувьд багтаж тусгай шаардлагыг хангаж байгаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Баттөмөр: Жавхлан сайд баярлалаа. Дараагийн танилцуулгыг Монгол Улсын 2024 оны төсвийн

төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол улсын ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат танилцуулна. Наранчимэг танилцуулна.

Ц.Наранчимэг: Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга, эрхэм гишүүдээ,

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг 7 зорилтын хүрээнд хянаж, үнэлэхэд аудитын зорилго чиглэсэн.

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан дараах шаардлагад нийцсэн гэж дүгнэж байна. Үүнд:

1.Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байна. Засгийн газрын өрийн үлдэгдэл дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх харьцаа 2024 онд 40.7 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв,

санхүүгийн аюулгүй байдлын бодлогын зохистой харьцаанд байна.

2.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25 их наяд 289.8 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34.2 хувь, нийт зарлага 27 их наяд 360.5 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37.0 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл 2 их наяд 70.8 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2.8 хувьтай тэнцэж байхаар төлөвлөсөн байна.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төслийн боловсруулахад Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан дараах зорилт, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

Шинэ сэргэлтийн бодлогод тусгасан хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх;

Хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, экспортыг дэмжих, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг эрчимжүүлэх;

Иргэдийн орлогыг хамгаалж, цалин, тэтгэвэр тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх, хөгжилд суурилсан хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх;

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлэх;

Уул уурхайн орлогоос орон нутгийн хөгжлийн санд нэмэлт орлого хуваарилах, иргэдийн ая тухтай амьдрах

орчныг сайжруулах, тогтвортой хариуцлагатай уул уурхайг дэмжиж, байгалийн баялгийн үр өгөөжийг орон нутгийн хөгжилд чиглүүлэх зэргийг тусгасан байна.

Засгийн газраас 2024 оны төсвийн төсөлд тус Байнгын хороонд харьяалагдах Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв дараах байдалтай байна.

Төрийн албаны зөвлөл 6.2 тэрбум, Авлигатай тэмцэх газрын даргын төсөв 45.8 тэрбум төгрөг байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн зардлын нийт дүн 2023 оны тодотгосон төсвөөс 14.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 52.0 тэрбум төгрөгөөр төсөвлөгдсөн нь Засгийн газраас 2024 онд нийт албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд хийсэн аудитын дараах дүгнэлтийг танилцуулж байна. Үүнд:

1.Төсвийн төсөлд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ, татварын орлого зэргийг өөдрөгөөр төсөөлсөн нь төсвийн гүйцэтгэлд эрсдэл үүсвэл, төсөвт тодотгол хийх нөхцөлд хүргэж болзошгүй байна.

2.Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийг боловсруулахдаа хөтөлбөр бүрийн өртгийг тооцоогүй, арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүйгээс төсвийн зорилго хангагдах эсэхийг үнэлэх боломжгүй байна.

3.Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналыг эрэмбэлэх, эдийн

засаг, нийгмийн ач холбогдол, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан эдийн засгийн бодит үр өгөөжийн тооцоо, судалгаа хийх аргачлалыг боловсруулан баталж Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.11 дэх заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.Гадаад өрийн төсөвт үзүүлэх ачааллыг бууруулах зорилгоор дотоод үнэт цаас гарган төсвийн алдагдлын тодорхой эх үүсвэрийг бүрдүүлэхээр төсвийн төслийг боловсруулсан боловч түүний үр ашгийг нарийвчлан тооцоолоогүй байна.

5.Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн ангилалд магадлал хийгдэж байгаа 21, нэг маягаар болон жишиг магадлалтай 153 төсөл, арга хэмжээг тус тус тусгасан байна.

6.Барилга байгууламжид зураг төсөл, магадлал хийх, худалдан авах ажиллагаа зохион байгуулах, гэрээ байгуулах, захиалагчийн хяналт болон гэрээний хэрэгжилтийг хангуулах, улсын комисс барилга байгууламжийг хүлээн авах зэрэг төсвийн хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулан субьектив сөрөг нөлөөллийг бууруулах эрх зүйн тодорхой нарийвчилсан зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Та бүхэнд дараах асуудлыг толилуулж байна аа.

Төсвийн тухай хуулийг хэлэлцэн батлахдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний зорилт, зорилго, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөвт тусгуулахад анхаарал хандуулахыг хүсэж байна.

Монгол Улсын Засгийн газар дараа оны төсвийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барихдаа төрийн аудитын байгууллагаас өгч буй дараах зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Монгол Улсын төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн барихдаа төсвийн төсөл боловсруулах тухайн үедэх хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэсэн байх,

Улсын хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн зөвхөн төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж байх,

Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл арга хэмжээний төсөвт өртгийн дүнд өөрчлөлт орж буй шалтгаан нөхцөлд нарийвчилсан судалгаа, дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээг авч ажиллах,

Барилга байгууламж, зураг төсөл, магадлал хийх ажлыг зохион байгуулах, худалдан авах үйл ажиллагаа гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх, улсын комисс хүлээн авах ажиллагаанд субьектив сөрөг нөлөөлөлгүй байлгах тодорхой нарийвчилсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох,

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-ийн дагуу хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх чиглэлийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгч, хэрэгжилтэд нь хяналт тавих,

Хөгжлийн бодлогод нийцүүлсэн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг

бүрэн хэрэгжүүлж, салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан албан хаагчдыг нэгдсэн арга зүйгээр хангаж чадавхыг сайжруулах гэсэн зөвлөмжийг хүргүүлж байна аа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Баттөмөр: Ерөнхий аудиторын орлогч Цэвэгсүрэнгийн Наранчимэгт баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн дэд сайд Санжаагийн Мөнгөнчимэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж, Сангийн яамны Санхүү, төсвийн газрын дарга Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чимэдсүрэн, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Энхболд, Энхтөрийн Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Ичинноров Сангийн яамны төсвийн хэлтсийн дарга, Ганзориг Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга. Тэгээд Сангийн яамны Төсвийн орлого, зарлагын хэлтсийн мэргэжилтнүүд оролцож байгаа юм байна.

Үндэсний аудитын газар Цэвэгсүрэнгийн Наранчимэг Ерөнхий аудитын орлогч, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ядамын Самбууням, Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна.

Баатарзориг Төрийн албаны зөвлөлийн дарга, Баатарсайхан Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Вандансүрэнгийн Жавзан Ажлын албаны дарга, Бат-Эрдэнэ Маргаан хянан шалгах газрын дарга, Азжаргал Авлигатай тэмцэх газрын дэд дарга, Баасаням Авлигатай тэмцэх газрын Тамгын

хэлтсийн дарга, Энхболд Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл болон Аудитын дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Бат-Эрдэнэ гишүүнээр тасалъя. Бат-Эрдэнэ гишүүнд микрофон өгье.

Б.Бат-Эрдэнэ: Манай Байнгын хорооны харьяа байгууллагуудын 2024 оны төсвийн танилцуулгыг үзэж байна. Улсын эдийн засагт бас сэргэлт гарч байгаатай холбоотой төсвийн төлөвлөлт бол бололцоотой болжээ гэж ингэж үзэж байгаа. Би нэг зүйл асуух гээд байгаа юм. Энэ бол төсвийн зарцуулалт, хэмнэлтийн хуультай нийцүүлэх, цаашилах юм бол Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуульд томоохон өөрчлөлт оруулсан. Төрийн эрх мэдэл бүхий энэ албан тушаалтнууд төсөл тендер цаашилах юм бол төр, ард түмний нэр барьж авсан зээл, бонд, элдвийн юманд оролцохыг нь бол хуулиар хааж өгсөн байгаа юм.

Үүний нөгөө талаар төрийн албыг төрлийн алба болгодог энэ байдлыг зохицуулсан хуулийн зохицуулалтууд байгаа. Хуучин өөрсдийнхөө дагаж явдаг цүнх баригчдыг намын дэргэдэх элдэв байгууллагаар дамжуулж энэ төр рүү чихдэг. Энэ нь бүр цаашаа гүнзгийрээд, өөрийнхөө эхнэрийг, нөхрийг дандаа удирдах албан тушаалд томилдог, өөрийнхөө үр хүүхдүүдийг феодалын угсаа залгамжлах ийм хуучны бурангуй ёс шиг ингээд төрийн албан тушаалуудыг зайдлуулдаг энэ байдлыг боль гэдэг ийм шаардлагыг би 20-оод жил энэ Их Хуралд тавьсан хүн. Ингээд харин Ерөнхий сайд Оюун-Эрдэнийн тэргүүлж байгаа Засгийн газар энэ асуудалд онцгойлон анхаарч, миний дээр хэлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг

сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх энэ хуульд томоохон өөрчлөлтийг оруулсан. Энэ хуулийн хэлэлцүүлгийн явц дунд энэ дундуур нь бас займчуулсан, зувчуулсан ийм заалт юмнууд оруулсан. Энийг хэрэгжилтийн түвшинд нь манай Ёс зүйн Сахилга хариуцлагын байнгын хороо хуулийн хэрэгжилтийн түвшинд Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, энэ холбогдох газрууд энийг бүр нэг бүрчлэн сайн шалгах ёстой. Энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш өөрийнхөө хамаарал бүхий этгээдүүдийг энэ даргын, төрийн албаны даргын албан тушаалуудаас зайлуулж байна уу, зайлуулаагүй аваад үлдэж байна уу гэдгийг нь олон тэд нийтэд ард иргэдийн мэдэх эрхийг хангаж энэ тал дээр онцгой анхаарах ёстой гэж би ийм зүйлийг хэлэх гээд байгаа юм. Энэ талаар холбогдох байгууллагуудаас би асуух гэж байна.

Нөгөө нэг юм нь бол Төрийн албаны зөвлөлөөс энэ төрийн албанд сонгон шалгаруулж байгаа байдал дээрээ нэлээн онцгой анхаарахгүй бол болохгүй байна. Шалгалт өгсөн нэртэй ирж байгаа хүмүүсийн ажлын чадвар, харьцаа хандлага, ёс зүйн асуудал асар их дутагдалтай ийм хүмүүс орж ирж байгаа шүү. Энэ нь бол эргээд төрийн нэр хүндийг унагадаг, иргэд олон түмнийг чирэгдүүлдэг, хүнд суртал гаргадаг, иргэд олон түмэнтэй харьцаа хандлага байхгүй, хүнд сурталтай ийм хүнийг яах вэ. Нөгөө авлигалын тухай асуудал ярина шүү дээ. Тийм хөшүүн, хойрго төрийн албан хаагчийг юугаар зөөллөх вэ гэхээр зэрэг гарыг нь хүндрүүлж байж л асуудлыг шийдэхээс өөр байхгүй тийм нөхцөл рүү шахаж байгаа, тулгаж байгаа. Дээрээс нь.../минут дуусав/

Б.Баттөмөр: Төрийн албаны зөвлөл Баатарзориг дарга хариулъя. 1 микрофоныг Баатарзориг даргад өгье.

Б.Баатарзориг: Эрхэм гишүүн Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Төрийн чиг үүргийг

хэрэгжүүлэхтэй холбоотой, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахтай холбоотой бүх шатын байгууллагууд анхаарлаа хандуулаад ажиллаж байгаа. Нэг үеэ бодвол ахиц дэвшил гарч байгаа. Ажлын эхлэлүүд бол байгаа. Тэгэхдээ 225205 төрийн албан хаагч ажиллаж байгаа. Эдгээр дотор сайн ч хүмүүс байна, саарч хүмүүс байна. Таны барьж байгаа зарчимтай ижил байгаа. Нэгдмэл бодлого барьж байгаа. Болзол, шаардлага хангагдаагүй төрийн албанд томилогддог ийм ойлголт бол байхаа больж байгаа аль болохоор. Гадаадад хүн зорчино гэвэл гадаад паспорттой хүн л зорчих ёстой. Тэр шиг төрийн албаны, ялангуяа тусгай алба, захиргааны албанд томилогдох хүмүүс заавал ерөнхий шалгалт өгсөн байх болзлыг тэр тусмаа захиргааны албанд тавьж байгаа. Нийт 15 мянган төрийн албан хаагч нөөцөд байна. Таны хэлж байгаагаар танил талаа харж томилогдох, хамаарал бүхий этгээдээ томилох сонирхол төрөх ийм зүйлүүдийг бид нар тусгай шалгалтын зарчмаар аль болохоор урьдчилан сэргийлж, таслан зогсоох ажиллагаа явуулж байгаа. Зарим зүйлүүд дээр санал нэг байна. Сонгон шалгаруулалтаар томилогдсон сайн ч хүн байна, саарч төрийн албан хаагч байна. Гагцхүү чадавхын зарчмыг үндэслээд мэдлэг боловсрол, туршлага, ажлынх нь үр дүн гээд томилох ийм зарчим барьж байгаа. Гэхдээ сонгон шалгаруулалтын явцад томилогдсон зарим салбар зөвлөлүүд дээр томилогдсон хүмүүс хангалтгүй ажиллах, хүнд суртал гаргах, хууль бус үйлдэл хийхийг санаархах ийм үзэгдлүүд байгаа. Энэ дээр бид нар бүх шатын байгууллагууд тэмцэж байна.

Нийт 5100 зөрчлийг илрүүлж, хүчингүй болгох ажиллагааг үе шаттай явуулсан. Өнгөрсөн 7 хоногт бид Өвөрхангай аймагт ажилласан. Өмнө бол зөрчил их өндөр тоотой аймгуудад гардаг, 4 зөрчлийн тоо илрүүлсэн. Нийслэлийн Сүхбаатар дүүрэг дээр ажилласан, 1 зөрчил илрүүлсэн.

Харьцангуй хууль бус томилгоо хаагдах ажлын эхлэлүүд байгаа. Жишээ нь Нийслэлийн Чингэлтэй дүүрэг дээр гэхэд 34 зөрчил, хууль бус томилгоо хийгдсэнийг бид нар хугацаатайгаар үүрэг өгөөд, ингээд хууль бус томилгоотой хүмүүсийг чөлөөлөх ажлууд бол хийж байгаа. Таны барьж байгаа зарчимтай нэг байгаа. Засгийн газар, Улсын Их Хурлаас барьж байгаа хууль бус үйл ажиллагааг шүүрдэх “5Ш” үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа болно. Асуулт асуусанд танд талархлаа илэрхийлье. Баярлалаа.

Б.Баттөмөр: Бат-Эрдэнэ гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр зэрэг бол ер нь энэ улс орны оршихуй, улс орны хөгжил, эдийн засгийн баталгаа, бүх юмны суурь бол ёс зүй, ёс суртахуун дээр суурилна гэдгийг бол бид бүх түвшиндээ хүлээн зөвшөөрч байгаа. Ийм ч учраас энэ ёс зүйн шаардлагыг тогтоохын хамгийн эхнээс нь бол шатыг дээрээс нь шүүрдэх энэ зарчмын дагуу Улсын Их Хурлын гишүүдийн ёс зүйн дүрмийг шинэчилсэн найруулгаар бид баталсан. Манай Байнгын хороо. Үргэлжлүүлээд Төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хуулийг баталсан. Хэрэгжилтийг нь хангах гээд ид ажил явж байна. Цаашилах юм бол нийгмийн хүрээнд Хүмүүнлэг боловсролын хуулийн тухай асуудал яригдаж байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн хэрэгжилтийг бүрэн хангахад манай харьяа байгууллагууд идэвхийлэн хамтарч... /минут дуусав/

Б.Баттөмөр: Адьяаа гишүүн үг хэлэх юм уу дараа нь. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Танилцуулга болон Аудитын дүгнэлттэй холбогдуулан төсөвтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу. Нэрсээ өгнө үү. Баярсайхан гишүүнээр тасалъя. Адьяаа гишүүн.

Ш.Адьяаа: Өнөөдөр 2024 оны улсын төсөв хэлэлцэж байна. Манай Байнгын хороогоор Улсын Их Хурлын харьяа байгууллагуудын төсөв, хөрөнгийн асуудал орж ирсэн байна. Өнөөдөр бид төрийн албан хаагчдад ёс зүйн талаар, сахилга хариуцлагын талаар маш өндөр шаардлага тавьж байгаа. Үүнтэй уялдуулаад бас энэ шаардлага тавихын зэрэгцээгээр төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, цалин хангамж, нийгмийн асуудал, тоног төхөөрөмж бусад зүйлийг нь тодорхой хэмжээгээр нэн яаралтай шийдэх ийм шаардлага байгаа юм. Бид өнөөдөр бүх шатад шаардлага тавиад байгаа. Сахилга хариуцлага, ёс зүй, үүрэг шаардаад байгаа. Гэтэл нөгөө талаасаа энэ хүмүүсийн ажиллах нөхцөлийн тухай, цалин хангамжийн тухай, нийгмийн баталгааны асуудлыг бид төрийн бодлогын хэмжээнд энэ төсөв хэлэлцэж байхад бас тодорхой хэмжээгээр шийдэх ёстой гэж бодож байна. Шийдэх ёстой гэж бодож байгаа. Энэ тэтгэвэр, цалин хөлс гээд л олон зүйлүүдийг бид энд ярилаа. Энэ жилжингээ л ярьсан. Тэгээд л сүүлд нь тэтгэвэр, цалин хөлс дээр өнөөдөр бас л олон маргаан дагуулсан, шийдэл дагуулсан асуудлууд байна. Энэ Улсын Их Хурлын харьяа байгууллагуудын тухай бас төсөвтэй холбогдуулаад ярих санхүү, хөрөнгө оруулалтын асуудлыг нь энэ хэмжээнд нь Сангийн яамтай зөвшилцөж шийдсэн юм байгаа биз. Би энэ хүмүүсийн цалин хангамжийн, тоног төхөөрөмжийн асуудлыг харин ч бас төсвийн шийдэл гарвал нэмэгдүүлэх ямар юм байна гэдэг дээр бид бас ярих ёстой гэж бодож байгаа. Бид нар өнөөдөр сургууль, эмнэлгийн асуудал гээд л цалин, тэтгэвэр гээд байгаа болохоос энэ хүмүүсийн ажиллах нөхцөлийн тухай өнөөдөр Монголын төр шийдэж байж цаашидаа энэ хүмүүстэй сахилга хариуцлага, ёс зүйн асуудлыг ярих ёстой гэсэн ийм байр суурьтай байдаг юм. Дээр нь өнөөдөр энэ Улсын Их Хурлын харьяа байгууллагууд орж ирж байгаа учраас би бас ёс зүй, сахилга хариуцлагын асуудал “5Ш”

ажиллагаа гээд өнөөдөр энэ төр засгаас явуулж байгаа бодлогын хүрээнд бас ганц 2 үг хэлчихье гэж бодож байгаа. Хууль тогтоогчийн хувьд.

Төрийн албаны зөвлөл, Аудитын байгууллага гэдэг 2 байгууллагын тухай би энд ганц 2 асуудал ярья гэж бодож явдаг юм.

Төрийн албаны зөвлөл гэдэг энэ байгууллага бас нэлээн сайн ажиллаж байгаа. Ялангуяа Баатарзориг дарга бол бас энд бодлогын хэмжээнд нэлээн дорвитой бас хууль тогтоох байгууллагад ажиллаж байсан төрийн албанд бас ажиллаж байсан туршилагатай хүний хувьд бас сайн шийдэл олохын төлөө ажиллаж байгаа. Гэхдээ энэ дээр бас л их будилаан байдаг шүү. Ялангуяа тэр сонгон шалгаруулах асуудал дээр тэр Тамгын газрын дарга мэтийн ийм хүмүүсийн тэр хуулиа барьдаггүй олон асуудал байгаа. Энийг би төсөв хэлэлцсэний дараа мэдээж Улсын Их Хурал дээр энэ асуудлууд яригдах байх. Энэ сахилга ёс зүйтэй, төрийн байгууллагуудын ажлын хариуцлага, уялдааны тухай.

Аудитын байгууллагын тухайд бол төсвийн хяналт гэдэг юм чинь ер нь ямар зарчмаар яваад байна. Одоо энд бол сайхан хяналт гэдэг юм уншаад хуульд нийцсэн байна, нийцээгүй байгаа тухай асуудал яриад байдаг. Энэ аудитын байгууллага энэ дээр дүгнэлт хийгээрэй. Өнөөдөр ялангуяа энэ төсөв нэмэгдүүлдэг, тэр гүйцэтгэх, захиалагч байгууллагатай хамтарсан энэ төсөв нэмэгдүүлдэг асуудал чинь ер нь л их л хардлага төрүүлж байгаа шүү. Энэ дээрээ ер нь дүгнэлт хийгээрэй. Тэгээд л энэ захиалагчийн хяналт гэдэг юм юу байдаг юм. Гүйцэтгэгч, захиалагч 2 чинь нийлж аваад л явж байдаг. Тэгээд энэ дээр нь энэ улсын татвар төлөгчдийн мөнгө төгрөгийг бас үр ашигтай, зөв захиран зарцуулах энэ дээр бол төрийн аудитын байгууллага онцгой анхаарч, дүгнэлт хийж ажиллахыг л би хууль

тогтоогчийн хувьд хүсэж байгаа юм. Энэ дээр бол бүр онцгой анхаарах хэрэгтэй. Олон асуудал байна шүү. Ялангуяа энэ гүйцэтгэгч бараа, материалын үнэ нэмэгдүүлдэг, төсөв нэмэгдүүлдэг, хэд дахин нэг жил болоод.../минут дуусав/

Б.Баттөмөр: Адьшаа гишүүнд баярлалаа. Баярсайхан гишүүн үгээ хэлье.

Б.Баярсайхан: Одоо төсөв хэлэлцэж байна. Тэгээд жил болгон л нэг зүйл ярьсаар байгаад үнэхээр төдийлөн өөрчлөлт, шинэчлэлт гарахгүй байгаад бол урам хугарч байна. Юуны өмнө Эрүүл мэндийн даатгал төлдөг хүн, төлдөггүй хүн 2-ын хооронд бол бараг ялгаа байхгүй. Тэгээд ялгаа байхгүй учраас хүмүүс нь Эрүүл мэндийн даатгалыг төлөх дургүй байдаг. Үнэхээр яг Эрүүл мэндийн даатгал төлснөөрөө энэ хүн ямар үр дүнтэй, аз жаргалтай, эрүүл амьдарч байна гэдэг нь бол өнөөдөр төдийлөн төлдөггүй хүнээсээ ялгаатай биш ээ. Энэ дээр бодлогын шинэчлэл байна уу гэдгийг бол удаа дараа асууж байгаа. Төдийлөн ахиц өөрчлөлт юу ч байхгүй. Би энэ дээр зүгээр үг хэлэхдээ юуны талаар хэлэх гэсэн юм бэ гэхээр төрийн албан хаагчдын ёс зүйн асуудалд өнөөдөр ахиц дэвшил гарч байна гээд Баатарзориг дарга хэлж байна. Мэдээж ажиллаж байгаа юм чинь тодорхой хэмжээгээр байж л байгаа байх. Тэгэхдээ дахиад л энэ бол үр дүнтэй ажил биш байна. Өнөөдөр Улсын Их Хурал дээр Ёс зүйн дэд хороо Ёс зүйн байнгын хороо болж өөрчлөгдөөд, нийт ялангуяа төрийн албан хаагчдын ёс зүйн асуудал дээр ахиц дэвшил гаргана гээд ажиллаж байгаа. Энэ асуудал хэвээрээ. Энэ ногоон автобус гэдэг юм уу, нүүрс гэдэг юм уу, одоо энэ боловсролын салбар, хүүхдийн салбар хаа сайгүй ерөөсөө л ёс зүйн асуудал. Ингээд ярихаар цалин мөнгөний асуудал ярьж байгаа. Цалин мөнгө бага байна гээд өнөөдөр ёс зүйн алдаа гаргана гэсэн үг ерөөсөө биш. Тэгэхээр яаж бид энэ Монгол улс энэ салбар болгонд шигсэн

авлига, ёс зүйн асуудлаа бид нар цэгцлэх юм бэ.

Би Улсын Их Хурлын гишүүн болсноосоо хойш бүр үнэхээр ярьж байна шүү дээ. Яам болгоныг дамжиж явж байдаг, нэг салбарыг самраад, нөгөө салбар дээр очоод ингээд үймүүлж байдаг баахан сайд, Их хурлын гишүүд, дарга нарын нэр бариад явж байдаг. Өнөөдөр Их Хурлын гишүүдээ хулгайч гэж нэрлээд байж байгаа боловч ард нь тэр нэр нь тодроогүй баатрууд гэдэг шиг хэзээ ч Их Хуралд нэр дэвшихгүй. Төрийн албандаа ингээд л нэг салбар салбар дамжаад, хулгай хийгээд явж байдаг хүмүүсийнхээ энэ бүлэглэлийг хэзээ зогсоох юм бэ. Аудит хийгдээд байна гээд байх юм. Яагаад ингээд дээр нь очоод илээд яваад байдаг юм бэ. Яагаад асуудлын гүн рүү ордоггүй юм бэ. Яагаад өнөөдөр Авлигатай тэмцэх газарт очсон хэрэг, асуудлууд чинь ингээд чимээгүй хэрэгсэхгүй болоод яваад байдаг юм бэ. Энэ асуултыг л асуух гэж энэ Ёс зүйн байнгын хороонд би өөрөө ингээд гишүүнээр орж ирсэн. Өнөөдөр яг үнэндээ Төрийн албаны зөвлөл ажиллаж байна. Авлигатай тэмцэх газар ажиллаж байна. Өнөөдөр Улсын Их Хурал дээр Ёс зүйн байнгын хороо ажиллаж байна. “5Ш” шинэ сэргэлтийн бодлого, энэ шинэ сэргэлтийн бодлогын эхний 10 жилд хөгжил тушаа болж байгаа энэ ёс зүйн асуудалтайгаа тэмцэнэ гээд Засгийн газар нь бодлого шийдвэр гаргаад ингээд яваад байна. Тэгээд яагаад энэ ийм удаашралтай, бид нар ийм ёс зүйгүй хүмүүсээ төрийн албандаа байлгаад ингээд байгаад байгаа юм бэ л гэдэг асуултыг асууж байна даа. Тэгээд ажилд нь бол үнэндээ өөрчлөлт гарч байгаа юм алга.

Би энэ дээр энэ Ёс зүйн байнгын хороо дээрээ би хэлчихье. Энэ хүүхдийн 8 тэрбум төгрөгийн, хүүхдийн эрхийг хамгаалах 8 тэрбум төгрөг дээр 50 хувь нь алга болчихоод байна гэж байхад энд байгаа энэ байгууллагуудаас дуугарч байгаа хүн байхгүй. Санаа зовж байгаа

хүмүүс байхгүй. Тэгээд яг хүүхдийн асуудал нь дайн дажин болж байгаа юм шиг гамшиг болчихсон. Яагаад энэ дээр Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Аудитын байгууллага ажиллахгүй байгаа юм бэ. Яагаад энэ дээр та нар дуугарахгүй байгаа юм бэ. 8-хан тэрбум болохоор нь дуугарахгүй байгаа юм уу тээ. 50 хувь нь төсвийн гүйцэтгэл хэлэлцэгдэхэд тайлагнаж чадахгүй байна гэж хэлээд байна шүү дээ. Тэгээд Сангийн сайд аа, энэ мөнгө төсөв нэмэгдэх гэж байна. Энэ асуудал ингээд л байсаар байх уу. Хүүхдүүд гадна талд үхсээр л байх уу тээ. Тэгээд энд ажиллаж байгаа хүмүүсийнхээ ёс зүй, чадвар чадамжийг нь анхаараач ээ гэхээр анхаардаггүй. Авлигатай тэмцэх газар асуудал нь очихоор хэрэгсэхгүй болоод яваад байдаг. Энэ хүүхдээ л энэ байгууллагууд хамаарч чадахгүй бол бид нар энд чухал царайлж, Байнгын хороо дээр ийм том асуудал хэлэлцээд ч яах вэ. Үнэндээ ёстой урам хугарч байна. Энд байгаа бүх хүмүүс та нар аав ээж нар шүү дээ. Эмээ өвөө нар шүү дээ. Эгч ах нар шүү дээ. Тэгээд хүүхдэд төсөвлөсөн энэ мөнгө чинь ийм итгэмжгүй, энэ төрийн албан хаагч нар чинь ажиллахгүй байхад бид нар энд худлаа хуралдаад яах вэ дээ. Би зүгээр энийг асуулт асуухгүй. Үнэндээ зүгээр үг хэлээд, Ёс зүйн байнгын хороо учраас би яг энэ тал дээр үг хэлж байна.

Б.Баттөмөр: Баярсайхан гишүүн үг хэллээ.

Би хэдэн зүйл хэлье гэж бодож байна. Төрийн албаны зөвлөлийн төсөв 2,2 тэрбум 370 сая төгрөгөөр бараг 40-өөд хувиар нэмэгдэж байгаа. Энэ болбол Ёс зүйн хороо байгуулагдана. Энэтэй холбогдуулаад зардал байгаа. Яах вэ цалингийн нэмэгдэл гарч ирж байгаа. Сая манай гишүүд ярьж байна. Ёс зүйн асуудал. Бид нар өнгөрсөн 30 жилийн хугацаанд ёс зүй гэдэг юмыг ерөөсөө хаячихсан. Ямар нэгэн эрх зүйн акт гаргаж байгаагүй. Ёс зүй гэдэг үг хүний амнаас, удирдлагын амнаас бол гарч

байгаагүй. Ингээд хаячихсан учраас өнөөдөр ёс зүйн асуудал Монголд бол маш тулгамдсан асуудал болсон. Сая энэ зааланд хэд хоногийн өмнө том хэлэлцүүлэг болсон. Тэрнээс уриалга гарсан. Тэнд яригдсан юм бол юу гэхээр хөгжлийн саад бол юу гэхээр ёс зүйн асуудал болж ирж байгаа юм. Энэ дээр анхааръя гэж ийм зүйлүүд яригдсан.

Тийм учраас ёс зүйн хороогоо сайн байгуулаад бид нар өнөөдөр 3 гишүүнийг нь томилж өгнө. Ингээд ажиллах шаардлагатай. Ер нь бол Монгол улсын хөгжлийн мухардал бол хүнтэйгээ холбоотой. Энд бол Төрийн албаны зөвлөлийг буруутгах юм бол алга. Голдуу удирдлагын түвшиндээ байгаа. Төрд бэлтгэгдээгүй, туршлагагүй, мэдлэггүй ийм хүмүүс төрийн албанд томилогддог болчихсон. Очоод гологддог ийм л байдалтай байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр бол манай Төрийн албаны зөвлөл их бодолтой, сайн ажиллах ёстой.

Аудитын төсөв 11,5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж орж ирж байгаа юм. Цалин хөлстэй холбоотой зардлууд л голлож явж байгаа юм. Аудитын байгууллагын хувьд бол манай аудитын байгууллагыг би бол сайн ажиллаж байгаа гэж бодож байгаа юм. Харамсалтай нь аудитын дүгнэлтийг уншдаггүй, аудитын дүгнэлтийг ажил болгодоггүй ийм байдалтай байгаа юм. Тийм учраас энэ уншуулдаг болох ёстой юм байгаа юм. Энэ дээр манай аудитын байгууллага анхаарч ажиллах шаардлагатай.

Авлигатай тэмцэх газрын төсөв бол 12,6 их наяд төгрөгөөр нэмэгдэж байгаа. Энэ цалин хөлстэй холбоотой, янз бүрийн асуудлууд бол байгаа. Ер нь Монгол улсын хөгжлийн гарц бол юу вэ гэхээр авлигатай тэмцэх, хулгайтай тэмцэх ийм л асуудал байгаа. Эдийн засгаа тэлэх, хуримтлалтай болгох, энэтэй уялдуулаад энэ авлигатай тэмцэх. Энэ дээр бол маш их хүлээлтүүд байгаа Манай Авлигатай тэмцэх газар

бол боломжийн ажиллаж байгаа гэж ингэж бодож байгаа. Улам сайн ажиллах шаардлагатай. Авлигаас үүссэн боломжийн алдагдал хэдэн их наядоор хэмжигдэнэ. Авлигыг илрүүлж, авлигатай тэмцэж, үр дүн гаргаж чадах юм бол Монгол Улсын хөгжил тэр хэмжээгээр урагшилна. Ийм учраас Монгол Улсын Засгийн газраас төсвийг нь энэ 3 байгууллагууд дээр ингэж нэмэгдүүлж орж ирж байгаа. Ерөнхийдөө бол байдал та бүгд мэдэж байгаа. Гадаад, дотоод өр бусад зардлууд их шаардлагатай байгаа. Бүтээн байгуулалтуудыг хийх шаардлагатай. Энэ 3 байгууллагад бол ингэж онцгой анхаарч орж ирж байгаа нь ийм учиртай юм гэж ингэж ойлгож байгаа. Тийм учраас та бүгд энэ төсвүүд ингээд Улсын Их Хурлаар батлагдана. Батлагдсан төсвийнхөө түвшинд төсвийн сахилга батыг сайн хангаж ажиллах шаардлагатай гэж ингэж үзэж байна.

Ингээд гишүүд асуулт асуучихсан. Үг хэлж дууслаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын 2024 оны төсвийн төслүүд болон санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Төсвийн байнгын хороонд санал, дүгнэлт унших Улсын Их Хурлын гишүүнээр Бейсен гишүүнийг томилж байна.

Ингээд төсвийн холбогдолтой 2024 оны төсвийн хуулийн 2 дахь хэлэлцүүлгийг хийж дууслаа. Оролцсон та бүхэнд баярлалаа.

12.15 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгээс олонхын санал авсан нэр

дэвшигчийг Байнгын хороонд санал болгож, томилуулах тухай асуудал байгаа.

Нэр дэвшигчдийг оруулъя. Оролцоно шүү дээ. Байнгын хорооны Бейсен гишүүн байгаа. Бат-Эрдэнэ сайд байгаа.

2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хорооны 7 дугаар тогтоолыг гаргасан. Энэ дээр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын Ёс зүй сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 5 дугаар тогтоолоор баталсан Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 5-д заасныг үндэслэн Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүдийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн ахлагч нь Нямаагийн Энхболд Улсын Их Хурлын гишүү, ажлын хэсгийн гишүүд Бат-Эрдэнэ, Бейсен, Энэбиш, Адьяахишиг Хүний эрхийн комиссын Тамгын газрын дарга, Сувдмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хүний нөөцийн газрын хэлтсийн дарга, Ч.Бат-Эрдэнэ Төрийн албаны зөвлөлийн Маргаан таслах газрын дарга, Т.Энхболд Авлигатай тэмцэх газрын Хяналт шинжилгээний хэлтсийн дарга, Жолбарс Монголын хуульчдын холбооны Тамгын газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулсан. Ингээд Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн ахлагч Нямаагийн Энхболд ажлын хэсгийн тайлан, нэр дэвшигч нарыг танилцуулна. Нямаагийн Энхболд гишүүнд микрофон өгье.

Н.Энхболд: Байнгын хорооны дарга, гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4.2 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн

тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх заалт, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос баталсан Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 11 дүгээр зүйлийн 18.1-д заасны дагуу Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд олонхын санал авсан нэр дэвшигчийн талаарх ажлын хэсгийн тайланг Байнгын хороонд танилцуулж байна.

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 7 сарын 4-ний өдрийн 6 дугаар тогтоолоор Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдоор ахлуулан, гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, Баттөмөр Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль эрх зүйн газрын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Энэбиш Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Адьяахишиг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хүний нөөцийн газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Сувдмаа, Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Бат-Эрдэнэ, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Энхболд, Монголын хуульчдын холбооны Тамгын газрын дарга Жолбарс нарын 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

2023 оны 10 сарын 5-ны өдрийн Байнгын хорооны 5 дугаар тогтоолоор сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн оронд Улсын Их Хурлын гишүүн Бейсенийг оруулсан. Ажлын хэсэг нийтдээ 4 удаа хуралдсан.

Байнгын хорооны 2023 оны 7 сарын 4-ний өдрийн 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журам, 2 дугаар

хавсралтаар нэр дэвших тухай хүсэлт гаргах журам, 3 дугаар хавсралтаар ажлын хэсгийн гишүүний баталгаа гэсэн баримтуудыг баталсан. Үүний дагуу ажлын хэсгийн гишүүдээс зохих баталгааг гаргуулж авсан.

Сонгон шалгаруулах тухай зарыг 2023 оны 9 сарын 20-ны өдөр Өдрийн сонин, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн “Цагийн хүрд” нэвтрүүлэг, Улсын Их Хурлын цахим сайт, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны цахим сайт, Төрийн албаны зөвлөлийн цахим сайт, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр мөн сошиал сүлжээ ашиглан нийтэд мэдээлсэн. 2023 оны 9 сарын 20-ны өдрөөс мөн оны 9 сарын 29-ний өдрийн 17 цаг 30 минут хүртэл 10 хоногийн хугацаанд нэр дэвших сонирхолтой иргэдийн хүсэлтийг цахимаар болон бичгээр хүлээн авсан байгаа. Сонгон шалгаруулах журмын 7.2-т заасны дагуу нэр бүхий 7 хүн нэр дэвших тухай хүсэлтээ гаргаж, холбогдох материалаа ирүүлсэн. Энэ нэр дэвшигчдийн ирүүлсэн хүсэлт, холбогдох материалыг ажлын хэсэг 10 сарын 4, 5-ны өдрүүдийн хуралдаанаараа хэлэлцэж, сонгон шалгаруулалтад нэр дэвшигчээр бүртгэх эсэх асуудлыг ярьсан. Хүсэлт, материалаа ирүүлсэн 7 хүнээс журамд заасан материалын бүрдэл дутуу байсан 1 нэр дэвшигчийг бүртгэх эсэх асуудлыг тусгайлан хэлэлцэж, санал хураалт явуулаад ажлын хэсгийн олонхын саналаар бүртгэхээс татгалзсан болно. Мөн журамд заасны дагуу бүртгэсэн нэр дэвшигчийн талаар нэмэгдэл мэдээ цуглуулах, баримт судлах ажиллагааг 2023 оны 10 сарын 9-ний өдрөөс 16-ны хооронд хийсэн. Авлигатай тэмцэх газар, Боловсрол, шинжлэх ухааны яам, Улсын Бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газраас материалууд авсан. Мөн нэр дэвшигчдээс өөрсдөөс нь тодруулга, лавлагаа мэдээллүүд, нэмэлт мэдээллүүд гаргуулж авсан байгаа. Ингээд мөн журмынхаа дагуу ажлын хэсгийн гишүүд

2023 оны 10 сарын 18-ны өдөр Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд нэрээ дэвшүүлсэн Шаарийн Батсүх, Чогдонгийн Эрдэнэчимэг, Хорчингийн Ган-Очир, Дуламсүрэнгийн Оюунбилиг, Минжүүрийн Цэрэнбат, Ганбатын Мягмар нартай Төрийн ордны “Их засаг” танхимд хүн бүртэй тус тусад нь ярилцлага зохион байгуулсан. 2023 оны 10 сарын 19-ний өдөр ажлын хэсгийн хуралдааныг дахин хийгээд, нэр бүхий хүмүүс холбогдох журмын болзол хангасан гэж үзэж тэдгээрийг санал хураалтад оруулах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан. Ажлын хэсгийн гишүүн Адьяахишиг, Сувдмаа нар нэр дэвшигч Хорчины Ган-Очир, Дуламсүрэнгийн Оюунбилэг нар сонгон шалгаруулалт журмын 2.1.3-д заасан боловсрол, хүмүүнлэг, нийгмийн болон зан үйлийн шинжлэх ухаан, менежмент ба удирдахуй, эрх зүйн мэргэжлийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байх тухай шаардлагыг зарим хүн хангаагүй байна гэж санал гаргасныг ажлын хэсэг нягталж үзээд, хэлэлцээд олонхын саналаар Х.Ган-Очир, Д.Оюунбилиг нарыг дараагийн шатын нууц санал хураалтад оруулахгүй байх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн. Ингээд тооллогын комисс байгуулсан. Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнээр ахлуулж, нарийн бичгийн даргаар Тамгын газрын ахлах зөвлөх Энэбиш, гишүүнээр Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссоор Энхболд нар ажилласан. Ингээд тооллогын комисс нууцлал бүхий саналын хуудсыг баталсан. Энэ саналын хуудасны дагуу нууцаар санал хураалт явуулахад, санал хураалтад оролцсон ажлын хэсгийн 9 гишүүнээс Шаарийгийн Батсүхийг 8 гишүүн дэмжсэн, 1 саналын хуудас хүчингүй болсон. Чогдонгийн Эрдэнэчимэгийг 6 гишүүн дэмжсэн, 3 гишүүн дэмжээгүй. Минжүүрийн Цэрэнбатыг 8 гишүүн дэмжсэн, 1 хүн дэмжээгүй. Ганбатын Мягмарыг 4 хүн дэмжиж, 5 хүн дэмжээгүй дүн гарсан. Энэ дүнг харгалзаж үзээд Ёс зүй, сахилга

хариуцлагын байнгын хорооны хуралдаанд нууц санал хураалтаар хамгийн олон санал авч дэмжигдсэн Шаарийн Батсүх, Чогдонгийн Эрдэнэчимэг, Минжүүрийн Цэрэнбат нарыг хэлэлцүүлж, асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсэж байна.

Хуульд зааснаар бол Ёс зүйн хорооны орон тооны 4 гишүүн ажиллах ёстой. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд ажлын хэсгээс шалгарч гарч ирсэн 3 нэр дэвшигчийг танилцуулж байна. Иймд ажлын хэсэг цаашид ажлаа үргэлжлүүлээд Ёс зүйн хорооны дутуу байгаа 1 гишүүнийг гүйцээн шалгаруулах шаардлага байгааг илтгэж байна.

Нэмж хэлэхэд Байнгын хорооноос томилогдсон ажлын хэсгийн гишүүддээ талархаж байна. Манай ажлын хэсэг бол 9 хүний бүрэлдэхүүнтэй. Бүх хуралдаанд бүгдээрээ 9-үүлээ ярилцаж, оролцож, их идэвхтэй, хариуцлагатай, анхааралтай асуудалтай хандаж, энэ ажлыг зохион байгуулсан гэдгийг бас хэлэх нь зүйтэй гэж бодож байна.

Би танилцуулж дууслаа.

Б.Баттөмөр: Энхболд даргад баярлалаа. Ээр дэвшигч Шаарийн Батсүх, Чогдонгийн Эрдэнэчимэг, Минжүүрийн Цэрэнбат 3 сууж байна.

Тэгээд манай Байнгын хорооны гишүүдээс ажлын хэсэг болон нэр дэвшигчдээс асуулт асуух гишүүд байна уу. Нэрээ өгөөрэй. Адьшаа гишүүнээр тасаллаа. Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьяа: Нэр дэвшигч нараас асуух асуулт алга байна. Энэ 3 нэр дэвшигчийн төрийн албаны энэ ёс зүйн тухай хуулийн дагуу шаардлага хангасан ийм нэр дэвшигчид байна гэж ойлгож байгаа. Өнөөдөр Монгол Улсад энэ төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагын асуудалд Монгол төрийн

өмнөөс бас хариуцлагатай ажиллана гэдэгт итгэлтэй байна. Монгол Улсад өнөөдөр энэ сахилга хариуцлагын асуудал, ёс зүйн асуудал гэдэг юм шат шатдаа шийдээж байж, Монгол төрийн дархлааны асуудал, төрд итгэх итгэлийн асуудал бид ярих ёстой гэж ингэж бодож байна. Энэ сахилга хариуцлага, ёс зүйн асуудлыг энэ парламент бас онцгой анхаарч, энд бодлогоо хэрэгжүүлж ирсэн гэдгийг нь дурдаж хэлэхийг хүсэж байна. Энэ Улсын Их Хурлын бүтцийн байгууллагад Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо гэдэг Улсын Их Хурлын бүтцийн байгууллага байгуулж, энэ Их хурал энэ төрийн албаны ёс зүй, Монгол төрийн албан хаагчийн хүн чанар, үнэнч байх зарчмын тухайд бас бодлого явуулж ирсэн. Энэ үйл ажиллагааг төрийн бодлогын хэмжээнд анхааралтай оруулж ингэж ажиллахад манай Байнгын хорооны даргаар ажиллаж байсан Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Баагаагийн Баттөмөр нар бол үнэхээр бас санаачилга гаргаж ажилласан гэдгийг нь би бас тэмдэглэж хэлэхийг хүсэж байна.

Ингээд өнөөдөр энэ төрийн албаны ёс зүйн зөвлөл гэж Улсын Их Хурлын дэргэд ийм орон тооны бус ийм бүтэцтэй ийм байгууллага өнөөдөр байгуулагдлаа. Энэ байгууллага Монгол орны хэмжээнд төрийн нэр хүндийг өндөрт авч явах, ёс зүйтэй төрийн албан хаагчийг бий болгоход бүх зүйлийг бид зохион байгуулах ёстой. Өнөөдөр төрд итгэх итгэл алдарсан. Хуульд итгэх итгэл алдарсан. Энэ цаг үед бид маш их хариуцлагатай олон эрсдэлтэй тулгарна. Энэ дээр бол өргөсөн тангарагтай үнэнч байж, Монгол төрийн ёс зүй, сахилга хариуцлагын асуудал, Монгол төрийн албан хаагчийн чадварын асуудал гээд олон зүйл дээр хоёргүй сэтгэлээр ажиллах ийм цаг тулгарч байна гэдгийг би зориуд энд анхааруулж хэлье гэж бодож байна.

Тэгээд энд нэр дэвшиж байгаа хүмүүс бол бас салбартаа олон хууль, эрх зүйн хувьд мэдлэг чадварын хувьд, төрийн албанд ажилласан туршилагын хувьд энэ шаардлагыг хангасан ийм хүмүүс байна гэж ойлгож байгаа. Энэ Улсын Их Хурлын дэргэд байгуулагдсан төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагыг шалгаж, чиглэл өгдөг, дүгнэлт гаргадаг, хариуцлага алдсан хүмүүст хариуцлага тооцдог энэ системийг бий болгож байгаа нь бол маш хариуцлагатай алба. Энэ дээр бид нар бол нийт Монгол Улсын эрх ашиг, хууль дээдлэх зарчмын хүрээнд энэ ажлыг зохион байгуулах ийм шаардлага бол өнөөдөр нийгмээс тавигдаж байгаа гэдгийг энэ зориуд тэмдэглэж хэлье.

Тэгээд нэр дэвшигчдэд амжилт хүсье.

Б.Баттөмөр: Адьшаа гишүүнд баярлалаа. Энхболд гишүүн микрофон өгье.

Н.Энхболд: Би ер нь дүн гарсны дараа хэлье.

Б.Баттөмөр: Энэ Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүдэд тавих шаардлагыг бол нэлээн тод зааж өгсөн. Энд бол ёс суртахууны манлайлал үзүүлэх, олон нийтэд хүлээн зөвшөөрсөн нэр хүнд бүхий иргэн. Ажил мэргэжлийн үйл ажиллагааг нотлон харуулсан гэдэг ийм шалгуур байсан. Төрийн албаны туршилагатай, төрийн албан тушаалд бол тодорхой хэмжээний чиглэлээр ажилласан мэргэжлийн чиглэлээр ажилласан байх ёстой. Боловсрол, хүмүүнлэг, нийгэм болон зан үйл, шинжлэх ухаан, менежмент, удирдахуй, эрх зүйн чиглэлээр тодорхой дээд боловсрол эзэмшсэн байх. Нэр дэвших үед улс төрийн намын болон удирдах гүйцэтгэх албан тушаалд ажиллахгүй байгаа. Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй. Ёс зүй болон сахилгын шийтгэл ажлаас халагдаж байгаагүй, ямар нэгэн сэтгэцийн эмгэггүй байх. Ёс

зүйн хорооны бусад гишүүнтэй нэг анги төгссөн эсвэл хамаарал бүхий биш байх гэсэн ийм шаардлагууд бол байсан. Энэ шаардлагуудыг манай энэ 3 хүн хангаж байгаа гэж ингээж ойлгож байгаа. Ингээд асуулт асууж, хариулт авлаа. Үг хэлэх гишүүн байна уу. Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Ингээд сонгон шалгаруулалтад орж ирж байгаа хүмүүсийг бол мэдээж Их Хурлын дэргэд бүхэл бүтэн Монгол Улсын төрийн албаны ёс зүйг сахиулахад дээшилүүлэхэд хувь нэмрээ оруулъя гэж ингээж орж ирж байгаа хүмүүс гэж бодоод асуулт асуусангүй. Өөрөөр хэлбэл та бүхэнд итгэж байна.

Гэхдээ нэг зүйлийг бол хэлмээр байна. Өнөөдөр Монгол төрд итгэх хүмүүсийн итгэл алдагдаж, төрөө хүндэтгэх, дээдлэх гэдэг энэ зүйл ерөнхийдөө бол байхгүй болж байна. Нийгэм болгонд, салбар болгонд бугшсан энэ ёс зүйн асуудлыг шийдэхэд төрийн албан хаагчид илүү манлайлах хэрэгтэй байгаа юм. Төрийн түшигэд нь манлайлна. Төрийн албан хаагчид нь манлайлж байж ард иргэдийн төрдөө итгэх итгэл нэмэгдэнэ. Бид нар яг л ийм дарааллаар л явна. Гэтэл харамсалтай нь өнөөдөр 200 гаруй мянган төрийн албан хаагчид сайн хүмүүс байгаа. Чин сэтгэлээсээ ажиллаж байгаа хүмүүс байгаа. Энэ дотор төрийн албаны нэр хүндийг унагааж байгаа, гутааж байгаа ийм хүмүүс бол хаа сайгүй байна. Үүнээсээ цэвэрлэгдэж чадахгүй байна. Засгийн газар “5Ш” үйл ажиллагаа шүүр гээд л явуулаад л байна. Ерөөсөө яг ингээд л харахаар л энэ ажил нь төдийлөн сайн хэрэгжиж өгдөггүй. Тэгээд энэ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг бас санаачлан өргөн барьсан гишүүний хувьд та бүхний энэ хийх ажлыг бол нэлээн өндөр түвшинд хүлээлттэй байгаа гэдгээ өнөөдөр бас хэлмээр байна.

Миний хэлээд байгаа зүйл юу вэ гэхээр хууль хяналтын байгууллага нь

ажиллаад байдаг, аудит нь ажиллаад байдаг, Төрийн албаны зөвлөл нь ажиллаад байдаг. Одоо ингээд 9 гишүүнтэй хороо, зөвлөл ажиллах гэж байна. Ингээд хэдийгээр ажилласан ч гэсэн хууль хяналтын байгууллага, хүүхдийн салбар ерөөсөө салбар болгон саяын энэ нийслэл дээр гарч байгаа асуудлыг хар. Яаж энэ нийгмийг доройтуулах хэмжээнд энэ ажил хариуцаж байгаа хүмүүсийн ёс зүй доройтсон бэ гэдэг нь харагдаж байгаа. Ерөөсөө өнөөдөр Монгол Улсын хөгжихгүй байгаа шалтгаан бид нар ёс зүйн доройтолд орсон, хүмүүсийн хандлага энэ авлигын сүлжээ бүр шат шатад байгаа ийм асуудал л байгаа. Тэгээд энэ дээр та бүхэн маань үнэхээр зоригтой, дайчин, шударга үнэхээр ажиллаж чадвал энэ нийгмийг арай урагш нь явуулах, арай өөр түвшинд аваачихад хувь нэмэр оруулах л ийм л ажил байгаа.

Тэгэхээс биш дахиад л энэ дотор орж ирээд л тэр даргын хүн гэнэ лээ, энийг нь ярьж болохгүй юм гэнэ лээ гээд л бөөрөнхийлөөд яваад байвал энэ Ёс зүйн зөвлөл байсны ч хэрэг байхгүй ээ. Тийм учраас энэ нэр дэвшиж орж ирж байгаа энэ хүмүүсээ зоригтой, шударга, энэ Төрийн албаны зөвлөлийг бас үр дүнтэй ажиллахад нь нөлөө үзүүлэхүйц ийм хэмжээнд ажиллаасай гэж чин сэтгэлээсээ хүсэж байна.

Бид нар энэ ажлыг одоо л хийхгүй бол Монгол Улс байх юм уу, байхгүй юм уу, цаашаа ямар улс байх юм. Оршин тогтнох юм уу, тогтнохгүй юм уу гэдэг бүхий л энэ суурь асуудал чинь ингээд ганхчхаад байна шүү дээ. Ерөөсөө ёс зүйн асуудал, хүний хандлагын асуудал, ёс суртахууны асуудал, зан чанарын асуудал. Тэгээд би маш олон удаа л хэлж байгаа даа. Төрийн албаны зөвлөлөөс 5 жилийн өмнө маш том сургалт явуулж байсан. Энэ дээр төрийн албанд ороход нь ямар сургууль төгссөн нь 1 дүгээрт чухал биш. Ямар хүн болж төлөвшсөн нь 1 дүгээрт юм гэдэг энэ Сингапур улсын

төрийн албаны туршилагыг нэвтрүүлээд, анхандаа төрийн албанд орохдоо л тухайн хүнийхээ ёс зүйн хандлагыг шалгаж оруулж байгаач гэсэн энэ ажил хэрэгжихгүй байгаа. Ерөөсөө энэ хөгжссөн орнууд чинь яагаад байна гэхээр анх төрийн албанд оруулахдаа тухайн хүнийхээ хүмүүжил, төлөвшил, хандлагыг шалгачхаад, дараа нь тэр ямар сургууль төгссөн, хэдэн хэлээр ярьдаг, тэр нь 2 дугаар асуудал байна гээд байна шүү дээ. Тэгэхээс биш бид нарт анхны шалгуур нь маш бага, оруулсныхаа дараа ёс зүйн асуудал гардаг. Ёс зүйн хариуцлага хүлээлгэх гэхээр нууц биш шүү дээ. Энэ манай нийгэмд бүр нийтлэг асуудал. Нэг дарга цэргээр яриулдаг, сайд дарга нараар яриулдаг ийм л асуудал нүүрлэхээд байгаа шүү дээ.

Тийм учраас ард түмэн төрдөө итгэх итгэлгүй болоод байна. Монгол Улс хөгжлийн гацаанд орчхоод байна. Ийм л асуудал нүүрлээд байгаа. Тэгээд ийм том шинэчлэлийг хийх гэж ингэж орж ирж байгаа хүмүүс гэдгээ бас та нар маань ухамсарласан байх гэж найдаж байна. Тэгээд амжилт хүсье. Тэгээд ажил эхлээд явахад нь бол бас хэлэх зүйлээ хэлээд явна гэж бодож байна. Баярлалаа.

Б.Баттөмөр: Баярсайхан гишүүнд баярлалаа. Бас чухал санаанууд, дүгнэлт өгч байна. Та нар бас энэ дээр ажил дээрээ хэрвээ дэмжигдээд гишүүн болоод явах юм бол энийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай гэж ингэж үзэж байна.

Ингээд үг хэлж дууслаа. Нэр дэвшигч бүрээр санал хураалт явуулна. Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг батлагдсан. Энэ хуулийн дагуу Ёс зүйн зөвлөл, зөвлөлийн орон тооны бус гишүүдийг сонгон шалгаруулах энэ ажилд Байнгын хорооноос ажлын хэсэг гарсан.

Манай ажлын хэсэг бол түрүүн ажлын хэсгийн ахлагчийн танилцуулснаар бид тэр Байнгын хороо ч тэр манай ажлын хэсэг ч тэр маш ул суурьтай, хуулийн заасан хуулийн зохицуулалтын хүрээнд тал бүрээс нь бид нар их хариуцлагатай ингэж ажилласан шүү I дүгээрт бол энийг хэлье.

Тэгээд бас дэмжигдээгүй, санал аваагүй орон тоо гарсан байгаа. Энэ дээр бас дахиад сонгон шалгаруулах энэ ажил явагдах байх. Тэгээд ийм ийм асуудлууд яригдана. Тэгэхээр ер нь бол манай нийгмийн өнөөгийн болохгүй, бүтэхгүй байгаа юмны уг шалтгаан бол ёс зүйн тухай асуудал гэдгийг нийтээрээ бид ойлгож, хүлээн зөвшөөрч байгаа. Ялангуяа энэ эрх мэдэл, шийдвэр гаргах түвшиний хүмүүсийн ёс зүйн хандлага энэ байдлаас л манай орны өнөөгийн нөхцөл байдал бий болсон. Энэ чинь муу удирдагч байхаас биш, муу ард түмэн гэж байхгүй гэдэг үг байна шүү дээ. Тийм учраас нийгмийг хамарсан энэ ёс суртахууны өнөөгийн уналт доройтол, улс орны урагшаа хөгжихгүй дэвшихгүй байгаа үндсэн шалтгаан бол энэ 30 жилд төрийн албанд зүтгэсэн бүх хүмүүсийг хэлж байгаа юм биш. Төрийн энэ өндөр дээд ажил албан тушаалыг хашиж байгаа энэ хүмүүс дунд түрүүн Баярсайхан гишүүний хэлдэг энэ хандлага төлөвшил, нийтийн сайн сайхны төлөө нийтийн албанд тангараг өргөж зүтгэж байгаа гэдгээ ухамсарлаагүй ийм хувийн ашиг завшаан хайсан атгаг санаатай ийм нэг цөөхөн хэдэн хүмүүс Монголчууд хэлдэг шүү дээ. Ганц гайтдаггүй гэж. Ганц нэгхэн ийм хүмүүсийн байдал өнөөдөр ч таслан зогсоогдохгүй үргэлжилсээр л байгаа юм. Ийм хүмүүсийн ашиг сонирхлын зөрчилтэй авлига, хээл хахууль өөрийнхөө эхнэр нөхөр, үр хүүхдүүдээ, хамаатан саднуудаа төрийн албаар бүр 20, 30 жил ингээд бүүр шигээд энийг бүүр хувьчлаад авчихсан ийм хүмүүсийн байдал. Тэгээд энэ ард түмний төсөл тендер, хөрөнгө, бонд, зээл, лиценз ер нь хуруу хумсаа дүрэхгүй зүйл гэж байхгүй. Ингээд

нийгэмд ийм тэгш шударга боломжийг алдчихсан. Баян хоосны ялгаа туйлдаа хүрчихсэн. Нийгмийн ялгарлынх гарчихсан ийм хүнд нөхцөл байдал бол Монгол Улсын Засгийн газар 30 жилийн түүхэндээ анх удаа авлигатай тэмцэх жил болгож зарлаад, ингэж ажиллаж байгаа. Энэ бол яг үндсэн шалтгааныг нь бариад авчихсан, олчихсон гэсэн үг. Их хурал, Их Хурлын бүтцийн байгууллага бас мөн ялгаа байхгүй. Тийм учраас энэ бол өнөөдөр зарлаад, маргааш өргөс авсан юм шиг асуудал шийднэ гэсэн үг биш шүү дээ. Энийг бол бид нар бүх түвшиндээ аль аль талдаа ойлгох хэрэгтэй. Ийм зүйл юм. Ингээд бид нар бол ямар зарчим баримталсан гэхээр бид өөрсдөөсөө л эхлэх хэрэгтэй. Өөртөө л хатуу шаардлага тавина. Тийм учраас энэ Улсын Их Хурлаас эхлэх хэрэгтэй. Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмээ бид нар цэгцэлж авах ёстой. Тэр ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуульдаа өөрчлөлт оруулах ёстой. Энэ эрүүгийн хариуцлага, албан тушаалтнуудын авлига, ашиг сонирхолтой холбоотой асуудлын хэрэгт хүлээлгэх хариуцлагыг чангатгах ёстой гээд ингээд цогцоор нь асуудлууд шийдэгдээд явж байгаа. Одоо дээд талаасаа бол Улсын Их Хурлын түвшинд ажиллаж байгаа хүмүүс энэ 2024 онд орж ирэх, нэр дэвшүүлэх, сонгогдож орж ирэх хүмүүс бол энэ авлига, ашиг сонирхол энэ хувийн сонирхол гэдэг юмнаас бол ангид хүмүүс л орж ирэхээс өөр нөхцөл байхгүй. Энэ ашиг, төлөв байдал энэ бизнесийн салбарын хүмүүст ч гэсэн нэлээн хязгаарлагдах ийм нөхцөл байдал бол бий болж байгаа. Ингээд доошиггоо бүх түвшиндээ бид нар асуудлыг цэгцэлж явах ёстой. Тэгээд энэ асуудлыг цэгцлэх гол үүргийг хүлээж байгаа манай энэ хуулиар бий болж байгаа энэ Ёс зүйн зөвлөл хороонд өөрсдийнхөө сайнаар орон тооны бусаар та бүхэн маань энэ төрд ажилласан туршилага „хүлээн зөвшөөрөгдсөн байдлаараа та бүхэн маань чин шударгаар ажиллах ийм шаардлага тулгарч байгаа шүү. Энийгээ та бүхэн

минь ухамсарлаж, энэ хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн албыг цэвэр тунгалаг, нэр хүндтэй төрийн албан хаагчид маань шударга ажилладаг тэр шударга өргөсөн зарчимдаа үнэнч ажиллаж байгаагаараа соёл болдог дарга болох юм бол хөрөнгө завиш.../минут дуусав/

Б.Баттөмөр: Бат-Эрдэнэ гишүүн, сайдад баярлалаа. Мааш чухал асуудлуудыг хөндөж ярилаа. Одоо нэр дэвшигч бүрээ санал хураалт явуулна.

Улсын Их Хурлын Тамгын газраас Мэдээллийн технологийн хэлтсээс санал хураалтыг техникийн горимд шилжүүлсэн байгаа. Нууцаар санал хураана. Бэлэн үү. Турших уу. Санал хураалт. Гишүүд туршилтын санал хураалт. 1 хүн дутуу л таарлаа даа. Адьшаа гишүүн байхгүй. Адьшаа гишүүнээс асуугаадаа даа.

Нэр дэвшигч бүрээр нууцаар санал хураалт явуулна. Эхний санал хураалт Шаарийн Батсүхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 7 гишүүн оролцож 85,7 хувийн саналаар Шаарийн Батсүхийг дэмжсэн байна.

Дараагийн санал хураалтад бэлтгэе. Чогдонгийн Эрдэнэчимэг санал хураалт. Чогдонгийн Эрдэнэчимэгийг 71,4 хувийн саналаар дэмжлээ.

3 дахь санал хураалтад бэлдье. 3 дахь санал хураалт Минжүүрийн Цэрэнбатыг Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд томилъё гэсэн санал хураалтыг явуулъя. Минжүүрийн Цэрэнбатыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явна. Минжүүрийн Цэрэнбатыг 85,7 хувийн саналаар дэмжсэн байна.

Монгол Улсын байнгын хорооны тогтоол.

Ёс зүйн байнгын хорооны орон тооны улс гишүүнийг томилох тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.4.2 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийг үндэслэн Ёс зүй сахилгын хариуцлагын байнгын хорооноос тогтоох нь.

Монгол Улсын Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд Шаарийн Батсүх, Чогдонгийн Эрдэнэчимэг, Минжүүрийн Цэрэнбат нарыг томилгов.

Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ёс зүй, сахилгын хариуцлагын байнгын хороо /Б.Баттөмөр/, Төрийн албаны зөвлөл /Б.Баатарзориг/ даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна. Томилсугай. Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу. Алга байна. Илээр санал хураалт явуулна. Сая уншиж танилцуулсан Ёс зүйн хорооны орон тооны улс гишүүнийг томилох тухай Байнгын хорооны тогтоолыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 7 гишүүн оролцож 71,4 хувийн саналаар тогтоолын төслийг дэмжиж байна. Ингээд тогтоол батлагдлаа.

Энхболд гишүүн үг хэлье.

Н.Энхболд: Төрийн албан хаагчийн ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнээр сонгогдож байгаа Батсүх, Эрдэнэчимэг, Цэрэнбат нарт ажлын амжилт хүсье.

Би тэгээд товчхон энэ ер нь ямар учиртай хороо юм бэ гэдэг тал дээр хуулийн заалтуудыг бас эргээд сануулчихъя. Ёс зүйн хороо төрийн албаны төв байгууллагын дэргэд ажиллана. Ёс зүйн асуудал хариуцсан нэгжтэй байна. Энэ Ёс зүйн хорооны нийт 9 гишүүнтэй, 5 нь орон тооны, 4 нь

орон тооны бус байх ёстой. Орон тооны бус гишүүнийг Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо томилж, чөлөөлдөг. Сая Байнгын хороо шийдвэрээ гаргаад, 3 гишүүнийг нь томиллоо. Цаана нь 1 гишүүний асуудал үлдэж байгаа. Ингээд ер нь Ёс зүйн хороо ямар эрхтэй байгууллага юм бэ гэдэг тал дээр та бүхэнд ч хэрэгтэй байх. Мэдээж судалсан. Олон нийтэд ч хэрэгтэй байх.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг бууруулах чиглэлээр бодлого, үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьдаг. Хуульд өөрөөр заагаагүй бол Ёс зүйн дэд хороо томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх арга зүйн удирдлагаар хангах ийм эрхтэй, үүрэгтэй. Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтын агуулга хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, зохион байгуулах, энэ хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, энэ хуулийн 15.1-д буюу зөрчил гаргасан төрийн албан хаагч зөрчил гаргасан эсэхийг тогтоодог, дүгнэлт гаргадаг, үндэслэлийг нь гаргадаг. Энэ дүгнэлтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлдэг. Томилох эрх бүхий албан тушаалтнаас ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгээж байна уу, үгүй юү гэдэгт нь бас хяналт тавьдаг, хариуцлага тооцдог. Ёс зүйн дэд хорооныхоо ажиллах журмыг баталдаг. Бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад бичиг баримтыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулж авах эрхтэй. Ёс зүйн хууль тогтоомжийг зөрчсөн талаарх нэгдсэн дүн, төлөв байдлын тайлан гаргах ийм эрхтэй.

Тэгээд өөрөө энэ гишүүн бол хууль тогтоомж чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл автаж албан үүргээ шударгаар гүйцэтгэж байх, төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх, өөртэйгөө болон эхнэр, нөхөр, гэр бүл, садан төрлийн бусад гишүүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд оролцохоос татгалзах үүрэгтэй ийм Ёс зүйн хороо байгуулагдаж байгаа юм.

Ёс зүйн хорооны орон тооны 5 гишүүнд бол Төрийн албаны зөвлөлийн гишүүд буюу өнөөдрийн байдлаар Баатарзориг, Баатарсайхан, Идэрчулуун, Цэдэндамбаа, Амартөгс нар томилогдчихсон, Улсын Их Хурлаас томилогдон ажиллаж байгаа. Өнөөдрийн манай байнгын хорооны хуралдаанаас Батсүх, Эрдэнэчимэг, Цэрэнбат нар албан ёсоор орон тооны бус гишүүнээр томилогдож байна. Гэхдээ энэ хүмүүс бол бүгдээрээ адилхан эрхтэй, адилхан үүрэгтэй, адилхан хариуцлагатай хүмүүс шүү гэдгийг хэлэх байна. Түүрүүн би танилцуулга дээрээ бас хэлсэн. Одоо нэг гишүүний орон тоо дутуу байгаа. Баттөмөр дарга аа, тэгэхээр ер нь бол энэ манай ажлын хэсэг цаашид ажлаа үргэлжлүүлээд яг түрүүчийн явсан журмынхаа дагуу зараа хүргүүлээд, материал аваад танилцаад яг тэр журмаараа яваад үлдсэн 1 гишүүнээ шалгаруулах ажил үлдэж байгаа. Энэ дээр манай ажлын хэсгийн гишүүд яг урьдын адил маш хариуцлагатай, идэвхтэй оролцоно гэдэгт итгэж байна. Тэгээд дахиад энэ том үүрэг энэ том хариуцлагыг үүрч энэ Ёс зүйн хорооны гишүүнээр томилогдсон хойно бол орон тооны байна уу, орон тооны бус байна уу ялгаа байхгүй шүү дээ. Тийм ээ. Та нарын яг адилхан үүрэгтэй яг адилхан хариуцлагатай энэ олон Улсын Их Хурал, Байнгын хорооны итгэлийг хүлээж энэ шалгуурыг давж томилогдож байгаа ажилдаа хариуцлагатай ажиллаж, амжилттай ажиллахыг та бүхэнд хүсэж байна.

Б.Баттөмөр: Энхболд даргад баярлалаа. Манай ажлын хэсэг бол сайн ажилласан. Би Байнгын хорооны даргын хувьд бол ингэж дүгнэдэг юм. 24 хоног ажилласан, хийсэн ажлын тайлан тэр ширээ дээр байна. Манай гишүүд бас үзэж танилцаж болно. Бас нэлээн ярвигтай ажлын ард нь гарч ингэж хийлээ. 1 орон тооны бус гишүүн дутуу байгаа. Энийг ажлын хэсэг үргэлжлүүлээд зар мэдээг нь холбогдох газрууд цахим тэгээд бусад мэдээллийн хэрэгслээр зарлаад ингээд 1 гишүүнээ томилоод, ажлын хэсэг үргэлжлүүлээд хийчих нь зүйтэй гэж ингэж үзэж байна. Энэ ажлын хэсэг манай Энхболд дарга энэ 3 хүнээ Төрийн албаны зөвлөл дээр танилцуулаад, ажилд нь оруулчих нь зүйтэй гэж ингэж үзэж байна. 3 хүнээ аваачиж танилцуулаад, Та нарын хувьд бол ажиллах нөхцөл бүрдэнэ.

Энэ жил бид нар бас Ёс зүйн хорооны орон тоог бас боломжийн хэмжээнд 2024 онд бид нар тавиад өгчихсөн явж байгаа. 2023 оны хувьд бол бид нар бас энэ тодорхой төсөв зардлуудыг бид нарт нэмж гаргаж өгнө. Ажиллах нөхцөл тэр ажлын байрны асуудлууд бол Баатарзориг дарга шийднэ. Ингээд та нараас их зүйл хүлээж байгаа шүү. Та 3, дээрээс нь 1 хүн нэмэгдэнэ. Сая манай гишүүд ч ярьж байна. Нөгөө шатыг дээрээс нь цэвэрлэдэг. Төрийн албаны зөвлөл дээр энэ Ёс зүйн хороо ингэж байгуулж байгаа нь бол үнэхээр төрийн албанаас эхэлбэ. Энэ бол бусад төрийн бус байгууллагууд, хувийн компаниудад жишиг болж өгөх ёстой. Энэ утгаараа бол та нараас их зүйлийг харж байгаа. Хамгийн эхний ээлжид бол та нар 1 гишүүн бүрдээгүй байгаа ч гэсэн 8-уулаа болж байгаа учраас дэд хороо байгуулах журмаа батлах ёстой. Дэд хороо байгуулах. Төрийн албаны зөвлөл бол өөрөө бас нэлээн их ажилтай байгууллага. Тийм учраас бол ёс зүйн асуудлуудыг энэ 4 хүн голлоод ингээд цаашаа аваад явах ёстой. Дэд хороог байгуулаад дэд хороод томоохон Засгийн

газар хүртэл байгуулагдана. Тэгээд цаашаагаа яамнуудаар байгуулагдана. Томоохон төрийн өмчтэй газруудаар байгуулагдана. Төрийн өмчийн оролцоотой компаниудаар байгуулагдана. Энэ ёс зүйн хороо дэд хороог зөв байгуулснаар цаашидын ажил их сайн явна гэж бодож байгаа.

Монгол улсын хөгжлийн гарцын нэг бол энэ ёс зүйг дээшлүүлэх ухамсрын доройтлыг зогсоох, сэргээх, соён гэгээрүүлэх, төр засгийн бодлого шийдвэрийг ард иргэдэд зөв зүйтэй танилцуулах их олон ажлууд байгаа. Маш их олон ажлууд хийх шаардлагатай. Тийм учраас та бүгд сая Энхболд даргыг хэлдэг орон тооны бус ч гэсэн та нар бол ижилхэн эрхтэй. Ингээд 9 гишүүн тэгээд 5 гишүүнтэй адилхан эрхтэй ингээд ажиллана. Та бүгдийн ажилд бол Улсын Их Хурлын Ёс зүйн сахилга хариуцлагын байнгын хорооноос бид нар байнга дэмжиж, та нарын санал бодлыг сонсож ингэж ажиллана. Нийгэмд ямар ажлуудыг зохион байгуулмаар байна, ямар хэлэлцүүлгүүдийг хиймээр байна, юу хиймээр байна. Улсын Их Хурал юу хиймээр байна. Засгийн газрын түвшинд юу хиймээр байна. Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага. Хууль, дүрмийг гаргана. Юу хийх ёстойг нь та бүгдийн үнэтэй саналууд орж ирнэ гэж ингэж үзэж байгаа. Ингээд та бүгдийн ажилд амжилт хүсье.

Ёс зүйн хороо бол 9 гишүүнтэй байгаа. Төрийн албаны зөвлөлийн 5 гишүүн, дээрээс нь 4 гишүүн 3 нь өнөөдөр ингээд томилогдож байна. 1 гишүүнийг бол Энхболд дарга ажлын хэсгийн ахлагч холбогдох мэдээллийн хэрэгслүүдээр зарлаад энэ 7 хоногт багтаагаад зарлаад, тэгээд тодорхой хугацаанд тэр шалгууруудыг нь сайн зааж өгөөд, хүнээ сонгоод, 4 гишүүнийг бүрэн болгоод ингээд ажилд нь оруулах нь зүйтэй гэж ингэж хүсэж байна.

Ингээд та бүгдийн ажилд дахиж амжилт хүсье. Өнөөдрийн Ёс зүй,

сахилга хариуцлагын байнгын хороогоор хэлэлцэх тогтоолын төсөл байсан. Энэ дээр дахиж боловсруулах шаардлага үүссэн учраас дараагийн хурал хүртэл, ирэх 7 хоногийн хурал хүртэл хойшлууллаа. Ирэх 7 хоногийн хурлын хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулах нь зүйтэй.

Ингээд өнөөдрийн Монгол Улсын Их Хурлын Ёс зүйн сахилга хариуцлагын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууслаа. Идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

13.00 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ